# ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2017.07.05 Улаанбаатар хот

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан байдаг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

### 2.1.Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 68 хуулийн 262 заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 111 хуулийн 376 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 буюу 64.7 хувь, 204 заалт буюу 77.9 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 67 хуулийн 172 заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтнаас хассан хуулийн хэрэгжилтийн мэдээнүүд болно.

Мэдээнээс үзэхэд давхардсан тоогоор 77 хуулийн 170 заалт буюу 45.3 хувь нь хэрэгжсэн, 56 хуулийн 148 заалт буюу 39.4 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 5 хуулийн 9 заалт буюу 1.5 хувь нь хэрэгжээгүй, 11 хуулийн 29 заалт буюу 7.8 хувь нь хугацаа болоогүй, 13 хуулийн 17 заалт буюу 4.5 хувь нь үнэлгээгүй, 2 хуулийн 2 заалт буюу 0.5 хувь нь хүчингүй болсон байна.

### 2.2.Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн хэрэгжилт

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 27 хуулийн 81 заалтыг Хяналт үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар 24 хуулийн 71 заалт буюу хяналтанд авсан нийт хуулийн 88.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 15 хуулийн 48 заалт буюу 67.6 хувь нь хэрэгжсэн, 5 хуулийн 17 заалт буюу 23.9 хувь нь хэрэгжих шатанд, 3 хуулийн 4 заалт буюу 5.6 хувийн хэрэгжих хугацаа болоогүй, 2 хуулийн 2 заалт буюу 2.8 хувь нь үнэлгээгүй гэж ирсэн байна.

Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

| | **Хууль** /давхардсан тоогоор/ | **Заалт** | |
|---|---|---|---|
| | | **Тоо** | **Хувь** |
| Хяналтанд авсан | 27 | 81 | 100.0 |
| ***Үүнээс:*** | | | |
| Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн | 24 | 71 | 88.8 |
| ***Үүнээс:*** | | | |
| - Хэрэгжсэн | 15 | 48 | 67.6 |
| - Хэрэгжих шатанд | 5 | 17 | 23.9 |
| - Хугацаа болоогүй | 3 | 4 | 5.6 |
| - Үнэлгээгүй | 2 | 2 | 2.8 |

### 2.3 Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй

- 2015.05.29-ны өдрийн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, 15.7, 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалт;
- 2015.06.19-ны өдрийн “Захиргааны ерөнхий” хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь заалт;
- 2015.07.02-ны өдрийн “Галын аюулгүй байдлын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалт;
- 2015.07.08-ны өдрийн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн 14.4 дэх заалт;
- 2015.08.07-ны өдрийн “Галт зэвсгийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.10 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.6 дахь, 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтуудын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

## ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

### 3.1.Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын нийт 83 тогтоолын 303 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд, бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын нийт 74 тогтоолын 194 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд 9 тогтоолын 109 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 74 тогтоолын 194 заалтын 98 заалт буюу 50.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 73 заалт буюу 37.6 хувь нь хэрэгжих шатанд, 11 заалт буюу 5.7 хувийн хэрэгжих хугацаа болоогүй, 2 заалт буюу 1.0 хувь хэрэгжээгүй, 10 заалт буюу 5.2 хувь нь үнэлгээгүй ирүүлсэн байна.

### 3.2.Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний Улсын Их Хурлын 3 тогтоолын 5 заалт бүртгэгдсэн болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын тогтоолуудын хэрэгжилтийг бүрэн ирүүлсэн бөгөөд давхардсан тоогоор 2 тогтоолын 4 заалт бүрэн хэрэгжиж, 1 тогтоолын 1 заалтын хэрэгжилт нь 90 хувьтай байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

| | **УИХ-ын тогтоол** /давхардсан тоогоор/ | **Заалт** | |
|---|---|---|---|
| | | **Тоо** | **Хувь** |
| Хяналтанд авсан | 3 | 5 | 100.0 |
| ***Үүнээс:*** | | | |
| - Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн | 3 | 5 | 100.0 |
| ***Үүнээс:*** | | | |
| - Хэрэгжсэн | 2 | 4 | 80.0 |
| - Хэрэгжих шатандаа | 1 | 1 | 20.0 |

## ДӨРӨВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

### 4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 93 тогтоолын 505 заалтыг хяналтанд авснаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн байдлаар 55 тогтоолын 272 заалтын буюу хяналтанд авсан нийт заалтын 53.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 55 тогтоолын 272 заалтаас 42 тогтоолын 121 заалт буюу 44.4 хувь нь хэрэгжсэн, 37 тогтоолын 92 заалт буюу 33.8 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 8 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжээгүй, 7 тогтоолын 40 заалт буюу 14.7 хувь нь хэрэгжих хугацаа болгоогүй бол 8 тогтоолын 11заалт буюу 4.04 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

### 4.2. Хууль зүйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Хууль зүйн байнгын хорооны Засгийн газарт үүрэг өгсөн нийт 9 тогтоолын 59 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 5 тогтоолын 41 заалт буюу 69.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 5 тогтоолын 41 заалтын 17 заалт буюу 41,4 хувь нь хэрэгжсэн, 5 заалт буюу 12. 2 хувь хэрэгжих шатанд, 13 заалт буюу 31.7 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй, 2 заалт буюу 4.8 хувь нь тасарсан, 3 заалт буюу 7.3 хувь нь үнэлгээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

| | **УИХ-ын тогтоол** /давхардсан тоогоор/ | **Заалт** | |
|---|---|---|---|
| | | **Тоо** | **Хувь** |
| Хяналтанд авсан | 9 | 59 | 100.0 |
| ***Үүнээс:*** | | | |
| - Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн | 5 | 41 | 69.4 |
| ***Үүнээс:*** | | | |
| - Хэрэгжсэн | 5 | 17 | 41.4 |
| - Хэрэгжих шатанд | 4 | 5 | 12.2 |
| - Хэрэгжилт тасарсан | 2 | 2 | 4.8 |
| - Хэрэгжих хугацаа болоогүй | 2 | 13 | 31.7 |
| - Үнэлгээгүй | 2 | 3 | 7.3 |

### 4.3 Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй

- 2016 оны жилийн эцсийн тайланд Хууль зүйн байнгын хорооны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх хүний эрхийн үндэсний комиссын 11 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай” 2013 оны 2 дугаар тогтоолын “сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг нэн даруй шийдвэрлэх” тухай заалтыг зохион байгуулалтын шалтгааны улмаас;

- “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 15 дахь илтгэлийг хэлэлцсэн тухай” 2016 оны 10 дугаар тогтоолын “сэтгэцийн эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээний тусгай хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангах, эмчилгээ хийх орчин нөхцөлийг сайжруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх” тухай 1.4 дэх заалтыг санхүүжилт хийгдээгүй учир шийдвэрлээгүй гэж ирүүлсэн байна.

## ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар бүрэн биелэсэн дараах зүйл, заалтыг хяналтаас хасах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн байна.

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд үүрэг өгсөн 15 хуулийн 48 заалт, Улсын Их Хурлын 2 тогтоолын 4 заалт, Хууль зүйн байнгын хорооны 5 тогтоолын 16 заалтын мэдээг ирүүлсэн байна.

| Хууль тогтоомж | Тоо | Заалтын тоо | Хавсралтын дугаар |
|---|---|---|---|
| Монгол Улсын хууль | 16 | 48 | 1 |
| Улсын Их Хурлын тогтоол | 2 | 4 | 2 |
| Байнгын хорооны тогтоол | 5 | 16 | 3 |

**ЗУРГАА. САНАЛ**

1/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийж үнэлээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулан тайлбарлаагүй, хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлсэн байна.

2/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2012-2015 онд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтаа дахин ирүүлсэн байна.

4/ Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн нийт 17 хуудас жагсаалтыг хавсаргав.

**МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

Хавсралт 1

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Хуулийн нэр, огноо | Заалтын агуулга | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | **Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай** /шинэчилсэн найруулга/ | 11.7.визийн загварыг гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Виз олгох үндэслэлийг олон улсын жишигт нийцүүлэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулагад нэмэлт өөрчлөлт оруулахаар ГХЯ-ны Консулын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаад байна.<br>Визийн загварыг 2015 оны 3 дугаар сарын Хууль зүйн сайд болон Гадаад харилцааны сайдын хамтарсан А28/А58 дугаар тушаалаар баталсан болно. |
| 2 | **Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** 2011.12.15 | 12.1.7. Хүүхдийг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд цахим хэлбэрээр бүртгэхтэй холбогдох нарийвчилсан журмыг иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална. | УБЕГ /хуучин нэрээр/-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 1059 дүгээр тушаалаар “Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, бүртгэл хөтлөх журам”-ыг баталж, мөрдөн ажиллаж байна. |
| 3 | **Хүн худалдаалахтай тэмцэх тухай** 2012.01.19 | 12.1.5 гадаад улсад монгол улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах. | Гадаад улсад эрх нь зөрчигдсөн, хохирсон иргэдэд тэдгээрийн гаргасан өргөдөл, хүсэлтийг үндэслэн орон байраар хангах, шаардлагатай бусад дэмжлэг үзүүлж байна. Иргэдэд туслах сангийн журмаар 2016 онд нийт 30 иргэн, 39 ДТГ-т санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн. |
| 4 | **Захиргааны ерөнхий хууль** 2015.06.19 | 61.6. Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалыг Хууль зүйн сайдын 2016 оны 6 сард А222 тушаалаар батлан үйл ажиллагаандаа мөрдөж, ажиллаж байна. |
| 5 | **Галын аюулгүй байдлын тухай** /шинэчилсэн найруулга/<br><br>2015.07.02 | 12.5.гал түймэртэй тэмцэх гэрээт ангид алба хаагч ажиллуулах журам, гэрээний загвар, нэг алба хаагчид ногдох зардлын хэмжээг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/346 дугаар тушаалаар “Гал түймэртэй тэмцэх хэсэг ажиллуулах журам”-ыг батлуулж, мөрдөн ажиллаж байна. |
| | | 13.2. Гал түймэртэй тэмцэх хэсэг тогтоосон нутаг дэвсгэр, аж ахуйн нэгжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд уг хэсгийн ажиллах | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/346 дугаар тушаалаар “Гал түймэртэй тэмцэх хэсэг ажиллуулах журам”-ыг батлуулж, мөрдөн |

| | | | |
|---|---|---|---|
| | | журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, батална. | ажиллаж байна. |
| | | 20.2.галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандартыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр стандартчиллын үндэсний зөвлөл батална. | “Гал түймрээс хамгаалах, Барилгын гадна талын суурин шат, Дээврийн хязгаарлагч, техникийн шаардлага” MNS 6575:2016, “Гал түймэртэй тэмцэх, гал түймэр унтраах даралтын хоолой, Техникийн шаардлага” MNS 6576:2016, “Галын аюулгүй байдал, Нэр томъёо” MNS.ISO 13943:2016 стандартуудыг тус тус шинээр, “Гал түймэр унтраах, аврах, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр томъёо ба тодорхойлолт” MNS 639:2016 стандартыг шинэчлэн боловсруулж, Стандартчилалын Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. |
| | | 20.4. Галын аюулгүй байдалтай холбоотой барилгын норм, нормативын баримт бичгийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, салбарын галын аюулгүй байдлын дүрмийг холбогдох байгууллагатай зөвшилцөж онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална. | 2016 онд гадна болон дотор усан хангамжийн нормыг шинэчлэн боловсруулж, Барилга хот байгуулалтын яамтай зөвшилцөн БНББ-40-04-14, БНББ-40-05 баримт бичгийг батлуулсан.<br>2017 онд театр, үзвэрийн газрууд, соёл урлагийн байгууллагын галын аюулгүйн дүрмийг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. |
| 6 | **Сэтгэцийн эрүүл мэндийн тухай** /шинэчилсэн найруулга/ 2013.01.03 | 9.3.сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам, хугацааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Эрүүл мэнд ийн сайдын 2014 оны “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай” 180 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан. |
| 7 | **Хилийн боомтын тухай** 2013.12.06 | 6.2.боомтын хяналт шалгалтын бүсийн хэмжээ, хилийн заагийг Засгийн газар тогтооно. | 2016.12.28 -ны өдөр тухайн хуулийг хүчингүйд тооцох хууль батлагдан гарсан тул 2017.02.01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ. |
| 8 | **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай** 2015.01.29 | 18.7.улсын бүртгэлийн гэрчилгээний загварыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүйн сайд (хуучин нэрээр)-ын 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/204 дүгээр тушаалаар “Улсын бүртгэлийн гэрчилгээний загвар, тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | **Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай**<br><br>2013.07.05 | 10.3.улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх цалин хөлсний жишгийг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно. | Улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх цалин хөлсний жишгийг 2015 оны 4.23 -ний өдрийн А85/95 хамтарсан тушаалаар Хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтоосон болно. |
| | | 12.3.төвийн ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. | ЗГ -ын 2007 оны 354 р тогтолын заалтыг дүйцүүлэн тус төвийн ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын ангилал, зэрэглэлийг тогтоож байгаа болно. |
| 10 | **Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай**<br><br>2015.07.08 | 14.2.Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, сургалтын болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавина. | 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Стандартчилал хэмжил, зүйн Үндэсний зөвлөлийн хурлаар “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага. Ерөнхий шаардлага” MNS 6585:2016, “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтын төв. Ерөнхий шаардлага” MNS 6584:2016 стандартуудыг батлуулсан. Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/171, А/496 тоот хамтарсан тушаалаар “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”-ыг батлуулсан.<br>Мөн 2016 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр улсын нэгдсэн бүртгэлийн 3598 дугаарт бүртгэгдсэн.<br>Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/180, А/217 тоот хамтарсан тушаалаар “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”-ыг батлуулсан.<br>Мөн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр улсын нэгдсэн бүртгэлийн 3560 дугаарт бүртгэгдсэн.<br>Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/181, А/218 тоот хамтарсан тушаалаар “Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан. Мөн 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр улсын нэгдсэн бүртгэлийн 3561 дугаарт бүртгэгдсэн. Хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/185, А/405 тоот хамтарсан тушаалаар “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр”-ийг батлуулсан |

| | | | |
|---|---|---|---|
| | | 14.3.жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны болон жолоодох эрхийн шалгалт авах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдөр /шинэчлэн/ батлагдсантай холбогдуулан дагаж мөрдөх Хөдөлмөрийн сайд, Хууль зүйн сайдын 2015 оны А/180, А/217 дугаар тушаалаар баталсан “Тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн шалгалт авах журам”, Хууль зүйн сайдын 2015 оны А/186 дугаар тушаалаар баталсан ”Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, эрх сэргээх журам”-ыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.<br>Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төв нь улсын хэмжээнд давхардсан тоогоор 87584 иргэнээс Замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалт авснаас 63251, автодромын шалгалт 71521 иргэнээс авснаас 60258, замын хөдөлгөөний жолоодлогын шалгалт 58410 иргэнээс авснаас 56249 иргэн тус тус тэнцэж, давхардсан тоогоор 87584 иргэнээс шалгалт авснаас 56249 иргэн дээрх шалгалтуудад тэнцэж, нийт шалгуулагчдын 64.2 хувь нь жолооч болсон байна. |
| | | 15.4. Жолооны багшийн үнэмлэх олгох журам, жолооны багшийн үнэмлэхийн загварыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, жолоодох эрхийн үнэмлэх олгох журам, жолоодох эрхийн үнэмлэхийн загвар, үнийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална. | Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар "Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”-ыг нэгдүгээр, “Монгол улсын жолоочийн үнэмлэхний загвар”-ыг хоёрдугаар, “Монгол улсын Олон улсын жолоочийн үнэмлэхний загвар”-ыг гуравдугаар, “Жолоочийн түр зөвшөөрлийн загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар,<br>Монгол улсын “Жолоочийн үнэмлэх”-ний үнэ 12,500 төгрөг, “Олон улсын жолоочийн үнэмлэх”-ний үнэ 20.000 төгрөг байхаар тус тус баталсан.<br>Журмын хэрэгжилтийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвөөс 2016 онд улсын хэмжээнд үндсэн В ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох шалгалтад тэнцсэн 51559, үндсэн ВС ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох шалгалтад тэнцсэн 2130, А ангиллын эрх олгох шалгалтад тэнцсэн 4309, ангилал ахиулах буюу С ангиллын 10456, Д ангиллын 6591, Е ангиллын 4329, ДЕ ангиллын 632, М ангиллын 1845 иргэний материалыг хүлээн авч, жолоочийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан /TPS/-г баяжуулж шинээр үнэмлэх авах, ангилал ахиулсан үнэмлэх авах, гээгдүүлсэн, үрэгдүүлсэн үнэмлэх нөхөн авах, хуучин |

| | | | |
|---|---|---|---|
| | | | загварын үнэмлэх солиулах, гадаад орны жолооны үнэмлэх солиулах хүсэлт гаргасан 189877 хүнд жолооны үнэмлэхийг, Хууль зүйн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар баталсан.<br>Жолоодох эрхийн үнэмлэх олгох журмын 3.3 дугаарт заасны дагуу жолооны үнэмлэхний бэлдэц дууссантай холбоотойгоор жолооны үнэмлэхээ хаясан, гээсэн 51707 иргэнд жолоочийн түр зөвшөөрлийг тус тус хэвлэж олгосон байна. |
| | | 20.3. Замын хөдөлгөөн зохион байгуулах техник хэрэгсэл, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохионд тавих техникийн шаардлага, хэрэглэх дүрмийн үндэсний стандартыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, стандартчиллын төв байгууллага батална. | “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага. Ерөнхий шаардлага. MNS 6584:2016.” болон “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтын төв. Ерөнхий шаардлага. MNS 6585:2016.” стандартуудыг Стандартчилал хэмжил зүйн газрын дэргэдэх “Автотээврийн техникийн хороо”-ны хурлаар хэлэлцүүлэн, “Стандартчиллын үндэсний зөвлөл”-ийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлуулан мөрдүүлж эхлээд байна. МөнХөдөлмөрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2015 оны 218181 дүгээр тушаалаар “Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны журам”-ыг батлуулсан.<br>Мөн “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалтын төв. Ерөнхий шаардлага. MNS 6585:2016.” стандартыг “Стандартчиллын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлуулж, шалгалтын төв байгуулах асуудлыг Хөдөлмөрийн яамны холбогдох мэргэжилтнүүдтэй зөвшилцөж байна.<br>1. MNS 4759 : 2014 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага<br>2. MNS 4597 : 2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага<br>3. MNS 4596 : 2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм<br>4. MNS FED ST 141 : 2015 Авто замын тэмдэгний гэрэл ойлгогч болон будаг, лак зэрэг өнгөлгөөний бусад материалын чанарт тавих хяналт, дээж авах, турших арга<br>5. MNS EN 12966 : 2016 Шон суурьтай замын тэмдэг. Замын гэрэлтдэг тэмдэг<br>6. MNS 4912 : 2016 Авто замын тэмдэг болон дохионы төмөр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | бетон шон. Техникийн шаардлага<br>7. MNS FED ST 595 C : 2016 Авто замын тэмдэгний өнгөний код. Техникийн шаардлага Эдгээр стандартуудыг үндэсний стандартаар батлан мөрдүүлж байна. |
| | | 23.4.тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам", "Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам"-ыг Зам, тээврийн сайдын 2016 оны 90 дүгээр тушаалаар батлуулсан. |
| | | 6.1.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, хөтөлбөр батлах; | “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”-ийг Засгийн газрын 2012 оны 146 дүгээр тогтоолоор батлан, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратегийг хэрэгжүүлэх дунд хугацааны 2014-2016 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан. |
| | | 6.1.6.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, дүрмийг батлах. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, дүрмийн төсөл, санал боловсруулан хүргүүлсэн.<br>“Зам тээврийн сайдын 2017 оны 01 дүгээр 02-ны өдрийн 01 дүгээр тушаалаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний хороо” байгуулагдан ажиллаж байна.<br>Зам тээврийн хөгжлийн яамнаас 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хорооны анхдугаар хуралдаанд Замын цагдаагийн албаны дарга оролцож, Өмнөговь аймаг дахь уул уурхайн бүс орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлын нөхцөл байдал, орон нутгийн замд гарч байгаа осол хэргийн шалтгаан нөхцөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаарх мэдээллүүдийг хэлэлцэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг 2017-2020 оны дунд хугацааны стратеги болон үндэсний хорооны 2017 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, ажил, арга хэмжээний зардлуудыг төсөвт суулгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн |
| | | 8.3.замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах болон бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах, зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | 2015 оны 186 дугаар тушаалаар “Тээврийн хэрэгсэлжолоодох эрх дуусгавар болох, эрх сэргээх журам”, 187 дүгээр тушаалаар “Жолоочийн зөрчлийн оноо тооцох журам”, 188 дугаар тушаалаар “Бэлэн бус торгууль оногдуулах журам”, 189 дүгээр тушаалаар “Жолоочийн үнэмлэхний загвар үнийг тогтоолгож жолоочийн үнэмлэх олгох журам”, 190 дүгээр |

| | | | |
|---|---|---|---|
| | | | тушаалаар “Замын хөдөлгөөн зохицуулах, хянаж шалгах журам ба тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журмууд”- ыг тус тус батлуулан мөрдүүлж байна. |
| 11 | **Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**<br><br>2015.07.09 | 10.5.Монгол улсын зэвсэгт хүчний дээд удирдлагыг цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг тагнуулын ерөнхий газрын цэргийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг тагнуулын ерөнхий газрын дарга, зэвсэгт хүчний жанжин штабын даргатай хамтран батална. | ТЕГ, ЗХЖШ-ын даргын хамтарсан тушаалаар“ ТЕГ-ын ЦТГ-ын ажиллах дүрэм, журам”-ийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.<br>Хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. |
| | | 10.6.Хил хамгаалах байгууллагын дээд удирдлагыг хил орчмын нөхцөл байдлын талаарх тагнуулын мэдээгээр хангах чиг үүргийг тагнуулын ерөнхий газрын хилийн тагнуулын газар хэрэгжүүлэх бөгөөд тус газрын дүрэм, ажиллах журмыг тагнуулын ерөнхий газрын дарга, хил хамгаалах байгууллагын даргатай хамтран батална. | ТЕГ, ХХЕГ-ын даргын хамтарсан тушаалаар “ТЕГ-ын ХТГ-ын ажиллах дүрэм, журам”-ыг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталж, үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. |
| | | 5.гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийг худалдан авах, үйлдвэрлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэх, захиран зарцуулах, шилжүүлэх, устгахтай холбогдох харилцааг төрийн өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тагнуулын төв байгууллагын даргатай хамтран баталсан журмаар зохицуулна. | Сангийн сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн мн/155, а/мн/89 дугаар хамтарсан тушаалаар “Гүйцэтгэх ажлын зориулалттай эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ыг батлан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. |
| 12 | **Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**<br>2013.12.26 | 41.12. Тусгай хэрэгслийн жагсаалт, хэрэглэх, хадгалах зааврыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална. | Хууль зүйн сайдын 2014 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/90 дугаар тушаалаар “Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагч тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх, тусгай хэрэгслийг хадгалах заавар”-ыг 1 дүгээр хавсралтаар,<br>“Тусгай хэрэгслийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. |
| 13 | **Галт зэвсгийн тухай**<br>/шинэчилсэн | 10.3.спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журмыг спортын болон | “Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам”-ыг Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын |

| | | | |
|---|---|---|---|
| | найруулга/<br><br>2015.08.07 | хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | 2015.12.02-ны өдрийн 468 /А/268 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, улсын нэгдсэн бүртгэлийн 3586 дугаарт бүртгүүлэв.<br>Эрүүл мэнд,спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хамтарсан 468, А/268 тоот тушаалаар “Спорт-сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах журам” батлагдан хэрэгжиж байна. |
| | | 10.4. Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтыг цагдаагийн байгууллага зохион байгуулж, сургалтын зааврыг цагдаагийн төв байгууллагын дарга батална. | Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын зааврыг ЦЕГ-ын даргын 2015 оны 10 сарын 12-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталж, Улсын нэгдсэн бүртгэлийн 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3566 дугаарт бүртгүүлсэн.<br>ЦЕГ-ын даргын “Загвар батлах, зааварт нэмэлт оруулах тухай” 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/14 дүгээр тушаалыг баталж, Улсын нэгдсэн бүртгэлийн 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3566 н/ө-1 дугаарт бүртгүүлсэн.<br>ЦЕГ-ын даргын “Зааварт нэмэлт оруулах тухай” 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/59 дүгээр тушаалыг баталж, Улсын нэгдсэн бүртгэлийн 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 3653 дугаарт бүртгүүлсэн |
| | | 11.3. Нутгийн захиргааны байгууллага энэ хуулийн 11.2-т заасны дагуу шийдвэр гаргаж, ажиллах журмыг цагдаагийн байгууллагатай хамтран батална. | “Загвар батлах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталж, Улсын нэгдсэн бүртгэлийн 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3567 дугаарт бүртгүүлсэн. |
| | | 11.6.галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согогийн жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Эрүүл мэнд,Спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хамтарсан 469, А/269 тоот тушаалаар “Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, гэмтэл согогийн жагсаалт” батлагдан мөрдөж байна. |
| | | 11.9.спорт-сургалтын зориулалтаар ашиглах болон энэ хуулийн 16.6-д заасан төвийн буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавих шаардлагыг спортын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Эрүүл мэнд, Спортын сайд, Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хамтарсан 433, А/248 тоот тушаалаар “Спорт-сургалтын зориулалтаар ашиглах буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага”, Галт зэвсэг, сум худалдах төвийн буудлага үйлдэх байгууламж /тир/-д тавигдах шаардлага” тус тус батлагдан мөрдөгдөж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | 17.6. Борлуулагч галт зэвсэг, сумны дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх бөгөөд бүртгэлийн загварыг цагдаагийн төв байгууллагын дарга батална. | Галт зэвсэг, сумны бүртгэлийн загварыг "Загвар батлах тухай" Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталж, Улсын нэгдсэн бүртгэлийн 2015 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3567 дугаарт бүртгүүлсэн |
| | | 19.1.энэ хуулийн 16.1, 16.2, 16.5-д заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл импортлох, худалдах болон спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг Хууль зүйн сайд, Сангийн сайдын 2015.11.04-ний өдрийн А/251/304 дүгээр хамтарсан тушаалаар батлуулж, улсын нэгдсэн бүртгэлийн 3575 дугаарт бүртгүүлсэн. |
| | | 20.6. Энэ хуулийн 20.3-т заасан зөвшөөрлийн хуудасны загварыг цагдаагийн төв байгууллагын дарга батална. | "Загвар батлах тухай" Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаарсарын 12-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан. |
| | | 22.2.галт зэвсгийн тооллого явуулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүйн сайдын 2015.10.05-ны өдрийн А/220 дугаар тушаалаар “Галт зэвсгийн тооллого явуулах журам”-ыг батлуулж, захиргааны хэм хэмжээ тогтоосон актын улсын нэгдсэн бүртгэлийн 2015 оны 3563 дугаарт бүртгүүлсэн. |
| | | 23.3.хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль зүйн сайдын 2015.10.05-ны өдрийн А/219 дугаар тушаалаар “Хураагдсан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг устгах, худалдах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх журам”-ыг батлуулж, улсын нэгдсэн бүртгэлийн 3562 дугаарт бүртгүүлсэн. |
| | | 4.2.энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалтыг хууль зүйн, байгаль орчны болон спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Хууль зүйн сайд, Сангийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/251, 304 тоот хамтарсан тушаал “Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл импортлох, худалдах болон спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх журам” батлагдан хэрэгжиж байна. |
| | | 5.5.галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт, түүнийг ашиглах журмыг цагдаагийн төв байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт, түүнийг ашиглах журам”-ыг 2015.10.30-ны өдрийн А/249 дүгээр тушаалаар батлуулж, улсын нэгдсэн бүртгэлийн 3574 дүгээрт бүртгүүлсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | **Хууль тогтоомжийн тухай** /шинэчилсэн найруулга/<br><br>2015.05.29 | 12.1.Засгийн газар дараах аргачлалыг баталж, мөрдүүлнэ: 12.1.1.хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;<br>12.1.2.хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;<br>12.1.3.хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;<br>12.1.4.хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;<br>12.1.5.хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал;<br>12.1.6.хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. | “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”;<br>“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”;<br>“Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”;<br>“Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”;<br>“Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”;<br>“Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал” Дээрх аргачлалууд нь 2016 оны 01 сард Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан. |
| | | 30.3.хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. | Тухайн журмыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаалаар баталсан болно. |
| | | 40.3.хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн цахим хувийг үйлдэх, баталгаажуулах, хүлээлцэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Эрх зүйн актыг боловсруулах ажлын төлөвлөгөөний дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.3-т заасан хууль тогтоомжийн санг бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журмам болон Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилах журмыг 2016 оны Хууль зүйн сайдын А221, А227 дугаар тушаалаар баталсан |
| | | 44.3.энэ хуулийн 44.2-т заасан хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. | Хууль тогтоомжийн сан бүрдүүлж, системчлэн ангилах журмыг Хууль зүйн сайдын 2016 оны 7 сард А221 дугаар тушаалаар баталсан болно. |
| **ЗГХЭГ-аас нийт 16 хуулийн 48 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэнд хяналт шинжилгээ хийгээд 12 хуулийн 42 заалтыг хасах саналтай байна.** | | | |

Хавсралт 2

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД**
**БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Хуулийн нэр, огноо | Заалтын агуулга | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | **Захиргааны ерөнхий хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2015.06.19 | 1.1 1/захиргааны ерөнхий хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх болон давхардал, зөрчлийг арилгах, уялдуулах үүднээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулан 2015 оны 10 дугаар сарын 01-ний дотор багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Захиргааны ерөнхий хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх болон давхардал, зөрчлийг арилгах, уялдуулах үүднээс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосны дагуу Хууль зүйн яамнаас боловсруулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ болон Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар баталсан. |
| | | 1.2 2/захиргааны байгууллагын албан хаагч, ажилтан, иргэн, хуулийн этгээдэд дээрх хуулийг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах. | 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх энэхүү хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 30 сургагч багш бэлтгэж, уг хуулийн талаарх танилцуулах сургалтыг яам, агентлаг, нийслэл сум, дүүрэг, 21 аймагт зохион байгуулж, 7000 гаруй захиргааны албан хаагчдыг хамруулсан билээ.<br>Хууль зүйн яам, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сантай хамтран зохион байгуулсан дээрх сургалтаа дүгнэж, цаашид хийх ажил, анхаарах асуудлын талаар харилцан санал солилцсон байна. |
| **ЗГХЭГ-аас нийт 2 тогтоолын 4 заалтыг хяналтаас хасах санал ирүүлсэнд хяналт шинжилгээ хийгээд 1 тогтоолын 2 заалтыг хасах саналтай байна.** | | | |

Хавсралт 3

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,**
**ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Тогтоолын нэр, огноо | Заалтын агуулга | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | **Хадгаламж, зээлийн хоршооны хохирогчдын талаар авах арга хэмжээний тухай** 2012.05.21 №:22 | 3/ хадгаламж зээлийн хоршооны төлбөрт хураагдсан, цаашид худалдан борлогдохгүй байгаа эд хөрөнгийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатны үнээр хохирогч нарт хувь тэнцүүлэн олгох боломжийг судлах, түүнчлэн худалдан борлогдоогүй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээг тогтоон худалдан борлуулах талаар хууль тогтоомжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авах | Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор “Борнуур ХК”-ийн нийт гаргасан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 561,934 ширхэг энгийн хувьцаанаас 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 363,965 ширхэг хувьцааг /тусгаарлан авсан 407 тэрбум төгрөгийн эд хөрөнгөд ноогдох хувьцаа/ үнэт цаасны бүртгэлээс хасч, тус хувьцаат компаний гаргасан нийт энгийн хувьцааг 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 197,969 ширхэгээр тогтоосон. “Борнуур” ХК болон “Даваанбулаг” ХК-ийн эд хөрөнгөнд хөндлөнгийн шинжээч томилон шинэчилсэн үнэлгээ тогтоолгон Иргэний хуулийн дагуу албадан дуудлага худалдаанд оруулан “Даваанбулаг” ХК-ийн эд хөрөнгийг 166,185,000 төгрөгөөр худалдан борлуулаад байна. |
| 2 | **Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх хүний эрхийн үндэсний комиссын 11 дэх илтгэлийг хэлэлцсэн тухай** 2013.01.16 №:02 | 1/шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хууль болон “цагдан хоригдсон болон хорих ял эдэлж байгаа этгээдэд мнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн ажилтан ирж үйлчлэх журам”, “иргэд, байгууллагаас шүүхийн | Засгийн газрын 2013 оны 322 тогтоолоор жил бүр байгууллагын тухайн жилийн үйл ажиллагаа, шаардлагатай хууль, хөтөлбөр, дүрэм журамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байгаа болно ТТАХ-ын нэгдсэн эмнэлэг, Цагдан хорих төвийн эмнэлэг, Тусгай мэргэжлийн сүрьеэгийн эмнэлэг, Хорих ангийн эмнэлгүүдийн бүтэц үйл ажиллагааны стандарт батлагдсан байна.<br>Хууль зүйн сайдын 2014.11.24-ний өдрийн А/204 дугаар тушаалаар нэршил өөрчлөгдөж “Хорих байрны дотоод журам” болон шинэчлэн батлагдсан.<br>ШШГЕГ-ын даргын 2013.02.06-ны өдрийн А/32 дугаар тушаалаар “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгэний журам” шинэчлэн батлагдаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | шийдвэр гүйцэтгэх байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”, “баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”, “ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох тухай” дүрэм, журмыг олон улсын стандарт болон үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгүй болгох, холбогдох тогтоол, дүрэм, журамд мониторинг хийж ажиллах. | |
| | | 3/ ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй ялтнуудын группын хугацааг сунгах зэрэг нийгмийн халамжийн асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх, тэдгээр хүмүүст тохирсон ажлын байр бий болгох, цалин хөлс олгох тал дээр тусгайлан анхаарах. | Хорих анги, албанд ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй ялтанг хорих ангийн дотоодын үйлдвэрлэлд ажиллуулж, шагналын хоног, цалин олгох асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэж байна.<br>Монгол Улсын ХАХНХ, ЭМС-ын сайдын А/85, 241 дүгээр тушаалаар батлагдсан “Иргэн /даатгуулагч/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хөдөлмөр зохицуулалт хийх зааврын 6-р зүйлийн 6.5 дахь хэсэгт “Шүүхий шийтгэх тогтоол гарч ял эдэлж буй ялтны “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгахгүй бөгөөд шинээр тогтоохгүй.<br>Хорих ял эдлэхээсээ өмнө тахир дутуугийн тэтгэвэр авч байсан ялтан нь эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын тогтоосон хугацаанд тахир дутуугийн тэтгэвэрээ авна.” гэсэн заалтыг дагаж мөрдөж байна.<br>2016 онд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй ялтнуудын эрх зүйн орчинг бүрдүүлэх, тэдний эрхийг хангахад чиглэсэн чөлөөтэй саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн зам талбай, ахуйн орчин нөхцлийг бий болгох, тэдний ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөр эрхлэх боломж нөхцөл, тохирсон ажлын байраар хангах, алдагдсан чадварыг нөхөн сэргээх, орлуулах протез, ортопедийн техник, технологийг нэвтрүүлэн ажиллаж байгаа бусад байгууллагуудтай хамтран ажиллах /нэн даруй шаардлагатай байгаа |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ялтнуудыг хамруулах/, өөрсдийн сонирхсон чиглэлээр нь мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулах, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг сайжруулах зорилгоор Тогтоол гүйцэтгэх газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/02 дугаар “Ажил эрчимжүүлэх тухай” тушаалаар үүрэг чиглэл өгч, нийт хорих анги, албадад хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. |
| | | 4/ ялтны хөдөлмөр эрхлэх, цалин хөлс авах эрхийг хангах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх асуудлыг судалж, дэс дараатай шийдвэрлэх, ялтныг аливаа албадан хөдөлмөр хийлгэх зэрэг зөрчлийг таслан зогсоох | 2015 оны эхний 11 сарын байдлаар нийт 3235 ялтанг ажлын байраар хангасан ба үүнээс үйлдвэрт 611, гэрээгээр 597, барилгад 271, бусад болон туслах аж ахуйд 1756 ялтан ажиллуулж, нийт 719,6 сая төгрөгийн цалин бодогдсон байна.<br>Үүнийг 2014 оны 10 дугаар сарын байдалтай харьцуулбал цалин 32,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Ялтны хөдөлмөрийн хөлснөөс шүүхийн төлбөрт 118,0 сая төгрөг суутган шилжүүлсэн бол ар гэрээс нь 1463,3 сая төгрөг барагдуулсан байна. |
| | | 5/ цагдан хорих болон хорих байрны стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр баталж, улсын хэмжээнд мөрдүүлэх, дууны болон дүрс бичлэгийн техник хэрэгслээр бүрэн хангаж тоноглох | “Хорих байгууллагын хамгаалалт, аюулгүй байдал, хяналтын тоног төхөөрөмж, ээлжийн бүрэлдэхүүний хүчин чадал, хүн нэг бүрийн агсамж, тусгай хэрэгслийн стандарт”-ыг боловсруулах ажлын хүрээнд “Хорих байгууллагын үйл ажиллагааны стандарт”-ыг боловсронгуй болгон шинэчлэн боловсруулж цагдан хорих болон хорих байрны стандартын талаар тусгагдсан. 2015 оны эхний хагас жилийн байдлаар Хорих 415, 425, 427, 433,435, 439 дүгээр ангиуд, Цагдан хорих 461 дүгээр ангид IR дохиоллын системийг шинэчлэн суурилуулсан. Хууль зүйн сайдын баталсан “Хорих ангийн дотоод журам”, “Хорих байрны дотоод журам”, “Сахилгын байр тусгаарлах тасалгааны журам”, “Хорих ангийн харуул хамгаалалтын болон ялтанд хяналт тавих журам”-аар алба хаагчдад нэгдсэн ойлголт өгөх зорилгоор хичээлийн хөтөлбөрийг бэлтгэн, тус 6 журмаар эмхэтгэл гаргаж хэвлүүлэн, алба хаагчдад хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа цагдан хорих байруудад энгэрийн телекамер тараасан. Мөн "Монгол эмбедэд систем" ХХК-ний хийж бүтээсэн периметрийн дохиоллын системийг Хорих 409 дүгээр ангид суурилуулан туршихаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хорих анги, цагдан хорих байруудын хамгаалалтын техник хэрэгслийг шинэчлэх орчин үеийн хамгаалалтын техник хэрэгслээр хангах ажлынхүрээнд нийт 50 телекамерыг тус тус суурилуулаад байна. |
| | | 8/хөнгөвчлөх /хоспис/ тусламж, үйлчилгээ үзүүлэх | Засгийн газрын Концессоор байгуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “сувилгаа-хөнгөвчлөх эмчилгээний төв” байгуулах асуудлыг |

| | | | |
|---|---|---|---|
| | | хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Монгол хүний бие махбод, сэтгэл зүйн онцлог, гэр бүл нийгэм, эдийн засгийн байдалд нийцсэн, хүртээмжтэй, үр нөлөөтэй, чанартай тогтолцоо бүхий хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | оруулж батлуулсан. ЭМС-ын сайдын “Заавар, журам батлах тухай” 2015 оны 08 дугаар сарын 26 ны өдрийн 329 дугаар тушаалаар “Хөнгөвчлөх эмчилгээний заавар”-ыг батлан, мөрдөж байна. |
| | | 9/хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох | ЭМС-ын сайдын “Заавар, журам батлах тухай” 2015 оны 08 дугаар сарын 26 ны 329 дугаар тушаалаар батлуулснаар эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн хөнгөвчлөх тусламж үйлчилгээндээ даатгалаас санхүүжилт авах эрх зүйн орчин бий болсон. |
| 3 | **“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br><br>2015.10.01<br>№:28 | 4/ гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн даруй хамгаалж, гэр бүлийн хүчирхийлэл бүрийг гэмт хэрэгт тооцож, хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах ял шийтгэлийн оновчтой хувилбарыг бий болгох шаардлагад нийцүүлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн батлуулах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах; | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэн найруулгыг УИХ-р батлуулсан бөгөөд 2017.02.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. |
| 4 | “**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл”-** | 3.3/ахмад настны эмгэг судлалын төрөлжсөн, мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж, тухайн чиглэлийн мэргэжилтнийг | Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдэнд үзүүлэх асаргаа сувилгааг сайжруулах хүрээнд Ахмад настны үндэсний төвийн харьяа Сэргээн засах сувиллыг 2016 оны 6 дугаар сард ашиглалтад оруулан бүтэц орон тоог 2016 оны 09 сарын 30-ны өдрийн А/154 тоот тушаалаар шинэчлэн батласан. |

| | | | |
|---|---|---|---|
| | **ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай** 2016.11.16 №:10 | бэлтгэн чадавхжуулах. | Шинэчлэгдсэн бүтцээр Сэргээн засах сувилал нь 38 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулж ахмадуудад сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглан нөхөн сэргээх цогц үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэж байна. Тус төвд ажиллах мэргэжлийн эмч, сувилагчдыг дадлагажуулж, ахмадад үйлчилгээ үзүүлэх чадварыг дээшлүүллээ. |
| 5 | **Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай** 2015.07.08 №:23 | 1/шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын төрийн холбооны суурь сүлжээний горимд суурилсан нэгдсэн сүлжээний орчин үүсгэх | Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх төсөл байгуулагдан 2013 оноос ажиллаж байгаа бөгөөд 6 ажилтантай сүлжээний дэд бүтцийг бий болгон, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага холбогдож, цагдаагийн байгууллагыг холбох ажлыг гүйцэтгэж байгаа болно. Тухайн байгууллагуудын хооронд цахим мэдээллийн солилцоо хийгдэж, үйл ажиллагаа тогтмолжсон. |
| | | 2/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэгтгэн, харилцан дамжуулах, хүлээн авах боломжийг бүрдүүлсэн программ хангамж, техникийн шийдлийг шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын бүртгэлийн системд тус тус нэвтрүүлэх | Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх төсөл байгуулагдан 2013 оноос ажиллаж байгаа бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэгтгэн, харилцан дамжуулах, хүлээн авах боломжийг бүрдүүлсэн программ хангамж, техникийн шийдлийг шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын бүртгэлийн системд тус тус нэвтрүүлэн ажиллаж байна. |
| | | 3/ цагдаагийн байгууллагын гомдол мэдээллийн болон мөрдөн шалгах ажиллагаа, гэмт хэргийн бүртгэл, прокурорын байгууллагын мөрдөн шалгах ажиллагаанд тавих хяналт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэлтийн мэдээллийг төвлөрүүлэн харилцан өгөгдөл солилцох дундын нэгдсэн сан, систем бий | Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх төсөл байгуулагдан 2013 оноос ажиллаж байгаа бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нэгтгэн, харилцан дамжуулах, хүлээн авах боломжийг бүрдүүлсэн программ хангамж ашиглаж хууль сахиулах байгууллагын хооронд хэрэглэж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | болгох | |
| | | 4/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн мэдээллийн сан, тогтолцоо бий болгох чиглэлээр холбогдох дүрэм, журмыг боловсруулах, сургалт зохион байгулах болон бусад арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх төсөл байгуулагдан 2013 оноос ажиллаж байгаа бөгөөд хууль сахиулах байгууллагын хооронд мэдээлийн солилцоог гүйцэтгэж байна |
| | | 5/цахим засаглалын суурь мэдээллийг бүрдүүлэх, төрийн байгууллага хооронд харилцан мэдээлэл солилцох, загварчлах зорилгоор Засгийн газрын түвшинд хэрэгжихээр төлөвлөж байгаа болон хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдтэй харилцан уялдуулах | Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх төсөл байгуулагдан 2013 оноос ажиллаж байгаа бөгөөд хууль сахиулах байгууллагын хооронд мэдээлийн |
| | **ЗГХЭГ-аас нийт 5 тогтоолын 16 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэнд хяналт шинжилгээ хийгээд 5 тогтоолын 14 заалтыг хасах саналтай байна** | | |